



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠒᠐᠒1 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/᠒᠒

Мандалговь

Цэргийн албан хаагчдад мөнгөн
урамшуулал олгох тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.11 дэх заалт, Батлан хамгаалахын сайд аймгийн Засаг даргатай 2021 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний ажил үйлчилгээ 5.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 318 дугаар тушаал, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад орчин цагийн шинэ үеийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд тус аймагт байрлалтай Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 278 дугаар байгууламжийн албан үүргээ амжилттай гүйцэтгэж байгаа тэргүүний дөрвөн алба хаагчид тус бүрд 500,000 (таван зуун мянга) төгрөгийн мөнгөн урамшууллыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Урамшуулалд хамрагдах алба хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Урамшуулалд шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүрэг гүйцэтгэгч (Л.Доржбат) нягтлан бодогч (М.Янжиндолгор)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210053